

Golomt Capital®

# БОНДЫН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



2025.02.05



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.99%
Хүннү	2028.01.19	8.650%	6.41%
Монгол 29	2029.06.05	7.875%	6.56%
Монгол 31	2031.07.07	4.450%	6.82%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын бондуудын өгөөж 5.07%-6.20% хооронд хэлбэлзэж, дунд болон урт хугацааны тогтвортой хөрөнгө оруулалт хайж буй хөрөнгө оруулагчдад боломж олгож байна.



## КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Хөгжлийн банк (DBM)	2026.03.07	11.00%	6.96%
Энержи Ресурс (MMC)	2026.09.13	12.50%	6.31%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	10.42%
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.53%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.92%-11.11%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

## Ам.долларын “Бонд”-ыг яагаад сонгох ёстой вэ?

Аливаа улсын Засгийн газар нь банкнууд болон компаниудаасаа илүү өндөр зээлжих зэрэглэлтэй, найдвартай байдаг. Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан нээлттэй бондуудын өгөөж 6.2-6.8% байна. Харин олон улсад бонд гаргасан дотоодын аж ахуйн нэгжүүдийн өгөөж 6.9-10.7%-ийн түвшинд байгаа нь ам.долларын хадгаламжийн хүүнээс 2-3 дахин өндөр өгөөжтэй юм. Иймд та ам.доллараар найдвартай хөрөнгө оруулалт хийхийг хүсвэл бид танд зөвлөж, хамтран ажиллахад бэлэн байна.

**Г.БИЛГҮҮН**  
/Ахлах Вип брокер/



## АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

АНУ-ын 20 жилийн засгийн газрын бондын өгөөж 4.807%-д тогтворжиж, 4.80%-ийн дэмжлэгийн түвшинд тулж байна. Өмнө нь 5.00%-ийн эсэргүүцлийг сорьсон ч давж чадаагүй нь богино хугацаанд өсөлтийн хязгаар байгаа гэдгийг илтгэж байна. Холбооны Нөөцийн Банкны бодлого тодорхой бус, инфляцын түвшин 2.9%-д өндөр хэвээр байгаа нь бондын өгөөж буурахгүй байх нөхцөлийг хадгалж байгаа ч бондын хүү 4.60% руу унах магадлалтай.


График 1. АНУ-ын урт хугацаат бондын өгөөж



Эх сурвалж: Tradingview

2024 онд манай улсын сарын дундаж импортын хэмжээ 960 сая ам.доллар болж, 2023 оны 700 сая ам.доллараас 37%-иар өссөн. Өмнөх онуудад валютын нөөцийн шаардлагатай хэмжээ 3.3 тэрбум ам.доллар байсан бол одоо сарын импортын өсөлт 960 сая ам.доллар байгаагаас шалтгаалж шаардлагатай хэрэгцээ 4.3 тэрбум ам.доллар болж нэмэгдсэн. Иймд ГВАН өссөн ч импортын хэрэглээ өсөж буй тул ам.долларын ханш 2025 он гарснаар аажмаар чангарч байна.

График 2. Ам.долларын төгрөгтэй харьцах ханш



Эх сурвалж: Tradingview





## БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

Биржийн бус зах зээлд өрийн хэрэгслийн нийт 102,936 ширхэг үнэт цаас 10,365,744,958 төгрөгөөр арилжаалагдсан. Үүнээс анхдагч зах зээлд 100,000 ширхэг үнэт цаас арилжаалагдаж 10 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлээ.




- **Рейтинг:** "А тогтвортой"
- **Нэрлэсэн үнэ:** 100,000 төгрөг
- **Жилийн өгөөж:** 18%
- **Хугацаа:** 2 жил
- **Татвар:** 5%
- **Хүүгийн төлөлт:** Улирал тутам

## Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



## БОНДЫН ЗӨВЛӨХҮҮД

8665-1177 | 8665-4422 | 8083-6622 | 8888-9183